


БАТЛАВ
ДҮНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ
М.АНХБАЯР





БАТЛАВ
“АДИЛ-ОЧ” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ
ЦЕГЕЛЬНИК.В.П



БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ
ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ, ХАНДИВ,
ТУСЛАМЖ ӨГӨХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

№ДУЗДТГ/УУ2024070214/

Мандалговь хот

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.10 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 179-р тогтоол, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалт, Дундговь аймгийн Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг үндэслэн нэг талаас Нутгийн захиргааны байгууллага Дундговь аймгийн Засаг даргын тамгын газрыг төлөөлж Дундговь аймгийн Засаг дарга М.Анхбаяр, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай хамаарах Өлзийт, түүнийг төлөөлж Өлзийт сумын Засаг даргын орлогч Х.Шинэбаатар /цаашид А тал гэх/, нөгөө талаас “Адил-Оч” ХХК РД: 2707969 /цаашид Б тал гэх/- ийг төлөөлж Ерөнхий захирал ЦЕГЕЛЬНИК.В.П нар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр талууд байгаль орчныг хамгаалах, Уурхай, төслийн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах чиглэлээр хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Б тал нь аймаг, орон нутгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.
- 1.3 Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлэлийн тухай, Татварын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд явагдана.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Гэрээний хамрах хүрээг Дундговь аймгийн Өлзийт сумын Хөтөл Ус -2 нэртэй жоншны орд дээр MV-006399 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Адил-Оч” ХХК-ийн уурхай (цаашид “төсөл” гэх)-үүдийн үйл ажиллагааны хүрээнд орон нутагтай хамтран ажиллах гэрээ гэж ойлгоно.
- 2.2 Хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэхэд талууд дараах үндсэн чиглэлүүдийг баримтална. Үүнд:
 - 2.2.1 Уурхай, төслийн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх,
 - 2.2.2 Байгаль орчныг хамгаалах,

- 2.2.3 Ажлын байрыг нэмэгдүүлэх,
- 2.2.4 Орон нутгийн жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг дэмжих,
- 2.2.5 Соёлын өвийг хамгаалах,
- 2.2.6 Боловсон хүчний бодлогыг дэмжих,
- 2.3 Нутгийн захиргааны байгууллага нь компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
- 2.4 Талууд хамтран энэхүү гэрээний 2.2.1-2.2.3-т заасан асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.
- 2.5 Б тал нь тусгай мэргэжил шаардахгүй ажлын байрыг нэн тэргүүнд үйлдвэр, уурхай байрлаж буй сумын иргэдэд санал болгох, дараагийн шатанд зэргэлдээх сумдын иргэдийг ажлын байраар хангах замаар орон нутгийн иргэдийг авч ажиллуулахад анхаарч ажиллана.
- 2.6 Б тал нь төслийн үйл ажиллагааны нөлөөнд өртсөн орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс орон нутгийн бизнесийг дэмжих төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар хамтран ажиллана.

ГУРАВ. НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН /А тал/ ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Ерөнхий зүйлс:

- 3.1.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана
- 3.1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх
- 3.1.3 Компани үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, ИТХ-д тавьж шийдвэрлүүлэх;
- 3.1.4 Гэрээний хэрэгжилтэд холбогдох төрийн байгууллагууд хяналт тавьж ажиллана
- 3.1.5 Аймаг, сумын хөгжилд оруулсан хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож, ил тод мэдээлнэ.
- 3.1.6 Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчилна.
- 3.1 Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр.
 - 3.1.1 Уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэхэд тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран ажиллана
 - 3.1.2 Уурхайн орчны аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллана.
- 3.2 Байгаль орчныг хамгаалах чиглэлээр.
 - 3.2.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний (БОМТ) хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийн хуваарь үнэлж, ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн дараа жилийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэх
 - 3.2.2 Б талаас орон нутагт зохион байгуулж байгаа байгаль орчны чиглэлийн танилцуулга, сургалт, өдөрлөгт иргэд, олон нийтийг идэвхтэй оролцуулна.
- 3.3 Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр.
 - 3.3.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байрны талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй хэлбэрээр хүргэх;
 - 3.3.2 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;
 - 3.3.3 Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах;
- 3.4 Мэдээлэх/ Санал авах/ Хэлэлцүүлэх чиглэлээр.
 - 3.4.1 Иргэдэд төслийн хэрэгжилтийн талаар мэдээлэх;
 - 3.4.2 Төслийн хэрэгжилтэд санал авах;

- 3.4.3 Гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймаг (сум, дүүрэг)-ийн ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсэний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх;
- 3.4.4 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэй байгуулсан орон нутагтай хамтран ажиллах гэрээний талаар иргэдэд мэдээлэх;

ДӨРӨВ. КОМПАНИЙН /Б тал/ ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Ерөнхий зүйлс.

- 4.1.1 Нутгийн захиргааны байгууллагатай хамтран байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана;
- 4.1.2 Гамшиг, осол, гал түймэр гарсан үед шаардлагатай туслалцаа үзүүлнэ.
- 4.1.3 Талууд гэрээний биенэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ын ИТХ-д хүргүүлнэ
- 4.2 Орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах, орон нутгийн санд дэмжлэг үзүүлэх чиглэлээр.
 - 4.2.1 Энэхүү гэрээний хүчинтэй байх хугацаанд талууд тохиролцсон үндэс дээр Аймгийн орон нутаг хөгжлийн сангийн 100080052400 тоот дансанд /60,000,000/ жаран сая төгрөг, Өлзийт сумын баяр наадамд /20,000,000/ хорин сая төгрөг; аймгийн олон нийтийн арга хэмжээнд /20,000,000/ хорин сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх,
 - 4.2.2 Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр.
 - 4.2.3 Уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэхэд нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллана;
 - 4.2.4 Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх авто тээврийн замын маршрутыг аймгийн “Ашигт малтмал тээвэрлэлтийн нэгдсэн маршрут”-тай уялдуулан аймгийн Засаг даргаар батлуулж, маршрутын дагуу, замын ашиглалт, засварыг хариуцан тээвэрлэлт хийнэ.
- 4.3 Байгаль орчныг хамгаалах чиглэлээр.
 - 4.3.1 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу ажиллаж, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан БОМТ-нд хянаж, дүгнэх ажлын хэсэгт жил бүрийн 11 сарын 01-ний дотор тайлангаа ирүүлж дүгнэлтийг гаргуулах;
 - 4.3.2 “Тэр бум мод үндэсний хөдөлгөөн, “Дундговио ногооруулья” дэд хөтөлберийн хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх;
- 4.4 Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх, ажиллах хүчинийг сургах чиглэлээр.
 - 4.4.1 Нийт ажлын байрны 3-с доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах;
 - 4.4.2 ОН-ийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар ОН-ийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;
 - 4.4.3 Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн ОН-ийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;
 - 4.4.4 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгоходо тухайн орон нутгийн хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох (тухайн нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн,) өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх;
- 4.5 Орон нутгийн жижиг дунд бизнесийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр.
 - 4.5.1 Орон нутгийн аж ахуйн нэгжийн санал болгосон бараа нь компанийн “Бараа, материал худалдан авах шалгуур үзүүлэлтүүд” болон үйлдвэрлэлийн хэрэгцээ,

зориулалт, шаардлага, чанарын үзүүлэлтийг хангаж байгаа тохиолдолд дэмжиж ажиллана.

4.5.2 Нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн хүнний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан тохиолдолд эхний эзлжинд худалдан авах бодлого баримтлах, компанийд шаардлагатай бараа, материал нийлүүлэх жижиг дунд үйлдвэрийн төсөл, хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

4.5.3 Гамшиг, осол, гал түймэр гарсан үед сайн дурын үндсэн дээр тухайн сум, орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон шаардлагатай бусад зүйлд туслалцаа дэмжлэгийг үзүүлнэ.

4.6 Мэдээлэл/ Санал авах/ Хэлэлцүүлэх чиглэлээр.

4.6.1 Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум, дүүрэг)-ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх;

4.6.2 Тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын З хоногийн дотор байршуулна.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХЯНАЛТ

5.1 Гэрээний хэрэгжилт болон холбогдох хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаа талаар Аймаг, сумдын Засаг дарга, холбогдох төрийн байгууллагууд болох (АЗДТГ, БОГ, ГХБХБГ, ХХҮГ, Татварын газар, Цагдаагийн газар, Авто тээврийн газар) гэх мэт байгууллагууд болон нутгийн иргэдээр дамжуулан хяналт тавина.

5.2 Гэрээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Засаг даргын орлогчоор ахлуулсан аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөл, тухайн сумын Засаг дарга, иргэний төлөөлөл гэсэн баг бүрэлдэхүүн гэрээний дагуу хянаж, дүгнэнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

6.1 Талууд гэрээний тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар улиралд багтаан дүгнэнэ.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

7.1 Талууд үйл ажиллагаандaa Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

7.2 Энэхүү гэрээг биелүүлэхэд талууд санаачлага гаргаж ажиллана.

7.3 Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

7.4 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь компанийг хуулиар хүлээсэн бусад үүргээс чөлөөлөл үндэслэл болохгүй.

7.5 Б тал гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

8.1 Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

8.2 Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС. БУСАД

- 9.1 Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 9.2 Давтагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Энэ тухайгаа нэг сарын өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.
- 9.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 9.4 Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарвал нөгөө талдаа 30 хоногийн өмнө харилцан бичгээр мэдэгдэнэ. Оруулсан нэмэлт өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



"АДИЛ-ОЧ" ХХК-ИЙН ХӨТӨЛ-УС 2
УУРХАЙН ДАРГА
Б.ДАВААДОРЖ/.....Б.ДАВААДОРЖ/
УТАС:11321450, 99027707
ХАЯГ: ХАЯГ: УЛААНБААТАР, ХАН-
УУЛ ДҮҮРЭГ, 15-Р ХОРОО, НАМУУН
ТӨГӨЛ ХОТХОН, 3Б

АЗДТГ-ЫН ХБТХОХ-ЫН мэргэжилтэн
М.ГАНЧИМЭГ/ /М.ГАНЧИМЭГ/
Утао 70502895
Дундговь аймаг, Нутгийн захиргааны ордон
Аймгийн Засаг даргын тамгын газар

